



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/304

Зуунмод

Ажлын хэсэг томилж, зардал  
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын болон төсөвт байгууллагуудад Засгийн газрын тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх “Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг”-ийг 2022 оны 06 дугаар сарын 02 ноос 04-ний хооронд зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг”-ийн ажлын хэсэгт ажиллах албан хаагчдын томилолтын зардлыг тухайн байгууллагаас олгохыг холбогдох хэлтэс, агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг даалгасугай.

3. “Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг”-ийн томилолт, шатахууны зардалд шаардагдах 4,971,422 (дөрвөн сая есөн зуун далан нэгэн мянга дөрвөн зуун хорин хоёр) төгрөгийг аймгийн төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, шилэн дансанд байршуулж ажиллахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д даалгасугай.

4. Захирамжийг хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Т.Хуягбаатар)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4122010865